



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/474

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” -ын 2.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4 дүгээр хуралдааны 4/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 60 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд ковид-19 цар тахлын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн иргэдийн дархлаажуулалтын вакцин татан авалт хийхэд ажиллаж буй аймгийн Засаг даргын Тамгын газрын 1009 ХОУ улсын дугаартай автомашины засвар, сэлбэгт шаардлагатай 3 491 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 3 491 000 төгрөг /гурван сая дөрвөн зуун ерөн нэгэн мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 оны батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zah A/474 Kh

Аймгийн Засаг даргын 2021 оны
09 дүгээр сарын 13-ны өдрийн
А/474 дүгээр захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 1009 ХОУ УЛСЫН ДУГААРТАЙ
АВТОМАШИНЫ ЗАСВАР, СЭЛБЭГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д.д	Засвар үйлчилгээний зардлын төрөл	Нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1.	Урд амортизатор	ш	2	198,000	198,0
2.	Хойд амортизатор	ш	2	191,000	191,0
3.	Наклад хойд	ком	1	436,000	436,0
4.	Наклад урд	ком	1	140,000	140,0
5.	Босоо тэнцүүлэгч урд, хойд	ш	4	120,000	480,0
6.	Агаар шүүгч	ш	1	197,000	197,0
7.	Нумны саваа шингээгч ээмэг	ком	1	280,000	280,0
8.	Дугуй 195.85R15 хэмжээтэй даацын дугуй	ш	4	295,000	1.180,0
НИЙТ ДҮН					3 491,0

-oOo-